

**“БОГД БАНК ХК-ЫН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН ЭРДЭНЭ ОВОГТОЙ БЯМБАЖАВЫН 2022 ОНЫ 3-Р УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН”**

Миний бие Э.Бямбажав нь Богд Банк ХК-ны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022.07.06-ны өдрийн А-1/779 тоот тогтоолоор ТУЗ-ын Хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байгаа билээ. Энэхүү тайланг “Банкны тухай хууль” (“Банкны Хууль” гэх), “Компанийн тухай хууль” (“Компанийн Хууль” гэх), Монголбанкны “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам” (“Журам” гэх), Богд Банк ХК-ын дүрэм (“Дүрэм” гэх) гэх мэт холбогдох хууль журмын дагуу 2022 оны 3-р улиралд ТУЗ-ын Хараат бус гишүүний хувьд гүйцэтгэсэн ажлаа тусгаж нэгтгэсэн болно.

1. Оролцон, ажилласан ТУЗ-ын хурлууд тэдгээрийн шийдвэр 2022 оны 09 дүгээр сарын 29-нд Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурал болсон. Уг ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцэж миний бие уг асуудлуудтай танилцсан болно.
 - Шинээр томилогдсон ТУЗ-ийн Хараат бус болон ердийн гишүүдийг танилцуулах
 - ТУЗ-ийн дэргэдэх хороодыг шинэчлэн өөрчлөх тухай
 - ТУЗ-ийг даргыг сонгох тухай
 - Гүйцэтгэх захирлын хагас жилийн гүйцэтгэлийг дүгнэх тухай
 - Богд банк ХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай
 - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай

Уг хэлэлцсэн асуудлыг миний зүгээс 100% дэмжиж оролцсон. ТУЗ-ийн дэргэдэх хороодыг шинэчлэн өөрчлөх тухай хэлэлцэж миний бие Эрсдэлийн удирдлагын хорооны дарга, Аудитын хорооны хурлын даргаар тус тус томилогдон ажиллахаар болсон.

2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Богд банканд өөрийн биеээр очиж Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо, Аудитын хорооны өмнөх үеийн үйл ажиллагаатай танилцаж, эдгээр хороодын холбоотой дүрэм журам, санхүүгийн тайлантай танилцсан болно.

Миний бие хараат бус гишүүнээр томилогдсон хугацаанд ТУЗ-ийн нийт 16 удаагийн хуралд оролцож Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журмын 5.2.3 дах заалтын дагуу Их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэл баталсан тухай тогтоол гараагүй болно.

Богд банк ХК нь Монгол улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох Монголбанкны дүрэм журмын дагуу банкны засаглалын хэрэгжүүлэн хангалттай сайн ажиллаж байна. Удирдлагын баг, ТУЗ-ын гишүүд, Хувьцаа эзэмшигчдийн хооронд харилцааны үл ойлголцол байхгүй, банкны шийдвэр гаргалт нэг албан тушаалтны хэт төвлөрөлгүйгээр зохих журмын дагуу явагдаж байна.

Заавал мөрдөх ёстой аливаа хууль, дүрэм журмыг зөрчсөн болон харилцагч, хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхүйц шийдвэр, үйлдэл банкны үйл ажиллагаанд гараагүй болно.

Цаашид Монголбанкны “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журмын 5 дугаар заалтын дагуу өөрийн хариуцаж байгаа ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг хангах ажиллаж, хийж гүйцэтгэсэн ажлыг журмын дагуу хариуцлагатайгаар гүйцэтгэж тайлагнан ажиллах болно.

БОГД Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн
2022.10.14

Э.Бямбажав.